



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Мэдлэгийн шалгалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2014 оны 102 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”-ийн 15.18-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний салбарт гарч байгаа аваар, саатал, ослын тоо төдийлөн буурахгүй байгаа тул салбарын төрийн өмчит үйлдвэр, компаниудын гүйцэтгэх захирал, дэд захирлууд, ерөнхий инженер, салбар, хэсэг, цех, хэлтэс, албаны дарга нар болон ахлах инженер техникийн ажилтнуудын мэдлэгийн төвшинг тогтоох зорилгоор техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмүүдээр мэдлэгийн шалгалт авах ажлыг 2021 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулсугай.

2. Цахилгааны аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрмээр шалгалт авах ажлын хэсгийг нэгдүгээр, Дулааны аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрмээр шалгалт авах ажлын хэсгийг хоёрдугаар, мэдлэгийн шалгалтад хамрагдах байгууллагуудын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ажлын хэсгийг удирдан зохион байгуулж, шалгалтын дүнг Сайдын зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Батзориг/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Х.Бекболат/-т нарт, ажлын хэсгийг ажиллах нөхцөл, боломжоор хангахыг энэхүү тушаалын хавсралтад заасан байгууллагын гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.

Н.ТАВИНБЭХ

170600191